



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2024/74/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Даланзадгад хот

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn

Аудитор: С.Одончимэг
Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2024.02.27 № 118

танай _____-ны № _____-т

МАНДАЛ-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
О.ОТГОНБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мандал-Овоо сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Мандал-Овоо сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар шинэ жилийн баярын арга хэмжээнд төсвөөс хөрөнгө зарцуулсан, төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжих хугацаагүй байхад гэрээ байгуулж хөрөнгө зарцуулсан, төсөв захирагч нь өөртөө шийдвэр гаргаж төсвөөс урамшуулал авсан, бараа материалыг хүлээж аваагүй орлого авч зарцуулалт хийсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 13.1.4, 15 дугаар зүйлийн 15.1.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, 18 дугаар зүйлийн 18.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.17 дахь хэсгийг үндэслэн гаргасан аймгийн Засаг даргын 2023 оны А/37 дугаар захирамжийн дагуу төрийн захиргааны албан хаагчид орон нутгийн нэмэгдлийг үндсэн цалингийн 60 хувиар тооцож олсон байна.

016920270

Аудитын гол асуудал

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2023 оны А/35 дугаар захирамжаар сумын хурдан тэмээний уралдаан зохион байгуулах үйл ажиллагаанд зориулж 11.9 сая төгрөгийг Гайхамшигт Мандал ХХК-д шилжүүлж, урьдчилж төлсөн зардлаар бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	25,565,000.00	37,465,000.00
34	УРЬДЧИЛГАА	0	11,900,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	0	11,900,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	25,565,000.00	25,565,000.00
35400	Хангамжийн материал	25,565,000.00	25,565,000.00
35410	Бичиг хэргийн материал	85,000.00	85,000.00
35420	Аж ахуйн материал	25,480,000.00	25,480,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	30,247,546.37	25,635,194.57
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	30,247,546.37	25,635,194.57
39200	Биет хөрөнгө	30,247,546.37	25,635,194.57
39203	Авто-тээврийн хэрэгсэл	53,380,555.48	53,380,555.48
39204	Хуримтлагдсан элэгдэл	-42,482,025.53	-44,261,377.37
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	12,917,900.00	15,617,900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-3,880,666.52	-6,813,466.40
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,696,000.00	13,696,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,384,217.06	-5,984,417.14
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	55,812,546.37	63,100,194.57
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	453,679.41	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	453,679.41	0
41300	Өглөг	453,679.41	0
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	453,679.41	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	55,358,866.96	63,100,194.57
51	Засгийн газрын хувь оролцоо	55,358,866.96	63,100,194.57
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,149,000.00	2,149,000.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,149,000.00	2,149,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	53,209,866.96	60,951,194.57
51210	Өмнөх үеийн үр дүн	60,350,989.81	53,209,866.96
51220	Тайлант үеийн үр дүн	-7,141,122.85	7,741,327.61
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	55,812,546.37	63,100,194.57

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	89,434,649.00	166,776,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	841,900.00	0
120	Нийтлэг татварын бус орлого	841,900.00	0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	255,000.00	0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	255,000.00	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	586,900.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	88,592,749.00	166,776,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,002,249.00	15,120,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,002,249.00	15,120,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	87,590,500.00	151,656,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	87,590,500.00	151,656,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	96,575,771.85	159,035,272.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	96,575,771.85	159,035,272.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	73,592,373.92	114,187,783.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38,073,893.90	73,234,056.45
210101	Үндсэн цалин	38,073,893.90	52,398,697.19
210102	Нэмэгдэл	0	20,835,359.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,081,206.58	9,156,484.30
210201	Тэтгэврийн даатгал	3,544,700.02	6,226,409.78
210202	Тэтгэмжийн даатгал	384,126.64	732,518.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	307,301.30	586,015.00
210204	Ажилгүйдлийн даатгал	76,825.34	146,503.79
210205	Эрүүл мэндийн даатгал	768,253.28	1,465,036.93
2104	Хангамж, бараа материалын зардал	8,400,590.00	6,469,891.00
210401	Бичиг хэрэг	625,900.00	383,500.00
210402	Тээвэр, шатахуун	3,619,200.00	5,682,891.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	405,490.00	403,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,750,000.00	0
2107	Томилолт, зочны зардал	708,000.00	708,000.00
210702	Дотоод албан томилолт	708,000.00	708,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,358,040.00	16,763,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,358,040.00	16,763,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,970,643.44	7,856,351.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,716,300.00	544,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,254,343.44	7,312,351.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,983,397.93	44,847,488.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,715,449.00	10,829,998.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,200.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,402,249.00	10,829,998.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,267,948.93	34,017,490.84
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,267,948.93	33,177,488.84
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0	840,002.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-7,141,122.85	7,741,327.61
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-7,141,122.85	7,741,327.61

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	88,847,749.00	166,776,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	255,000.00	0
120	Нийтлэг татварын бус орлого	255,000.00	0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	255,000.00	0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	255,000.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	88,592,749.00	166,776,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,002,249.00	15,120,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,002,249.00	15,120,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	87,590,500.00	151,656,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	87,590,500.00	151,656,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	88,847,749.00	164,076,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	88,847,749.00	164,076,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	65,864,351.07	119,229,111.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	37,600,214.49	73,687,735.86
210101	Үндсэн цалин	32,791,064.79	52,852,376.60
210102	Нэмэгдэл	4,809,149.70	20,835,359.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,081,206.58	9,156,484.30
210201	Тэтгэврийн даатгал	3,670,319.00	6,226,409.78
210202	Тэтгэмжийн даатгал	352,721.65	732,518.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	282,177.30	586,015.00
210204	Ажилгүйдлийн даатгал	70,544.35	146,503.79
210205	Эрүүл мэндийн даатгал	705,444.28	1,465,036.93
2104	Хангамж, бараа материалын зардал	8,400,590.00	6,469,891.00
210401	Бичиг хэрэг	625,900.00	383,500.00
210402	Тээвэр, шатахуун	3,619,200.00	5,682,891.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	405,490.00	403,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,750,000.00	0
2107	Томилолт, зочны зардал	708,000.00	708,000.00
210702	Дотоод албан томилолт	708,000.00	708,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,358,040.00	28,663,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,358,040.00	28,663,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,716,300.00	544,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,716,300.00	544,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,983,397.93	44,847,488.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,715,449.00	10,829,998.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,200.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,402,249.00	10,829,998.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,267,948.93	34,017,490.84
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,267,948.93	33,177,488.84
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0	840,002.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0	2,700,000.00

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0	2,700,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	2,700,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0	2,700,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	2,700,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0	-2,700,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,149,000.00	53,209,866.96	55,358,866.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,149,000.00	53,209,866.96	55,358,866.96
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0
Тайлант үеийн үр дүн	0	7,741,327.61	7,741,327.61
2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,149,000.00	60,951,194.57	63,100,194.57

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	152,046,700.00	118,479,111.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	152,046,700.00	118,479,111.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	151,646,700.00	118,079,111.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	102,335,300.00	73,687,735.86
210101	Үндсэн цалин	71,918,900.00	52,852,376.60
210102	Нэмэгдэл	30,416,400.00	20,835,359.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,791,900.00	9,156,484.30
210201	Тэтгэврийн даатгал	8,698,500.00	6,226,409.78
210202	Тэтгэмжийн даатгал	1,023,400.00	732,518.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	818,700.00	586,015.00
210204	Ажилгүйдлийн даатгал	204,700.00	146,503.79
210205	Эрүүл мэндийн даатгал	2,046,600.00	1,465,036.93
2104	Хангамж, бараа материалын зардал	6,482,100.00	6,469,891.00
210401	Бичиг хэрэг	384,100.00	383,500.00
210402	Тээвэр, шатахуун	5,687,000.00	5,682,891.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	411,000.00	403,500.00
2105	Нормативт зардал	91,300.00	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	91,300.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	0
210604	Урсгал засвар	500,000.00	0
2107	Томилолт, зочны зардал	709,700.00	708,000.00
210702	Дотоод албан томилолт	709,700.00	708,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,386,400.00	27,063,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,386,400.00	27,063,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,350,000.00	994,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	350,000.00	0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	994,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	400,000.00	400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.00	400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	400,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	152,046,700.00	118,479,111.16
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	152,046,700.00	118,479,111.16
320001	Орон нутгийн төсвөөс	152,046,700.00	118,479,111.16

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,279,998.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,279,998.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,850,000.00
2,108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,850,000.00
210,801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,850,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,429,998.00
2,132	Бусад урсгал шилжүүлэг	10,429,998.00
213,209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,429,998.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,120,000.00
1,311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,120,000.00
131,103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,270,000.00
131,104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,850,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 43.9 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 43.9 сая төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн 34.0 сая төгрөгийн шилжүүлгээр санхүүжилтийн эх үүсвэрийг бууруулаагүй, зарлагын дүнд тохируулах бичилт хийгээгүй тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайланд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 2.3 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг хөрөнгө оруулалтын зардлаар бүртгэж тайлагнаагүй,
- Аймгийн ИТХ-аас сумдын өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх, Улаан загалмайн дунд шатны хорооны үйл ажиллагааг дэмжих, сургалт арга хэмжээнд

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

зориулан олгосон 3.9 сая төгрөгийн дэмжлэг санхүүжилтийг 131103 тоот дансанд тайлагнасан,

- Санхүүгийн үр дүнгийн тайланд нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 1.5 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн,
- Санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн 3 дугаар улирлын элэгдэл хорогдлын зардлыг 1.8 сая төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 0.4 сая төгрөгийн караоке спикерийг аж ахуйн материалын зардалд тайлагнаж, хөрөнгийн орлогод бүртгээгүй байна.

Аудитаар нийт 14.6 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 1.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 11.9 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1.6 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй, шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй төсвийн шууд захирагчид сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж ажилласан.

3.1 Төлбөрийн акт

- Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит 14 дүгээр хуралдаан, хүндэтгэлийн баярт зориулж 0.8 сая төгрөгийн 33 ширхэг бэлэг, 0.1 сая төгрөгийн 4 ширхэг архи, 0.2 сая төгрөгийн 18 ширхэг шампанскийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15.1.7 "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах"-д заасантай нийцэхгүй байна.

3.2 Албан шаардлага

- Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/35 дугаар захирамжаар "Сумын хурдан тэмээний уралдаан зохион байгуулах" үйл ажиллагаанд зориулж 11.9 сая төгрөгийн хөрөнгө зарцуулж, "Гайхамшигт Мандал" ХХК-д гэрээ байгуулан шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 "төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх"-д заасантай нийцэхгүй байна.

- Бараа материалын тайланд бодитоор хүлээж аваагүй 20ш ананас, 325ш мэндчилгээ, 52ш медаль, 30ш өргөмжлөлийг орлогоор бүртгэж, зардлаар тайлагнасан, бараа материалын үлдэгдлээс бөөн дүнгээр зарлага гаргаж бүртгэл хөтөлсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга нь ИТХ-ын даргын 2023 оны А/38 дугаар захирамжаар албан хаагчдад ажлын үр дүнгийн урамшуулал цалин олгохдоо өөрийн нэрийг оруулан 1.5 сая төгрөгийн урамшуулал авч давуу байдал үүсгэсэн байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно" гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, холбогдох эрх бүхий албан тушаалтнаар шийдвэр гаргуулж ажиллах

Илрүүлэлт 2: Хурлын даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/34 дугаар захирамжаар албан хаагчид нүүрсний үнийн дэмжлэг үзүүлэхдээ ХХОАТ суутган тооцоогүй байна.

Энэ нь Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дүгээр тушаалаар баталсан "Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын 2.2 "Суутган төлөгч нь хууль тогтоомжид тусгайлан заагаагүй "Хөдөлмөрийн дотоод журам" зэрэг зөвхөн тухайн байгууллагын баримт бичиг, шийдвэрийг үндэслэн олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламжийг албан татвараас чөлөөлөхгүй"-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон 2 албан хаагчдад төлбөрийн Е баримт үүсгэж татварт хамруулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитыг газарт 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайланд орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн 34.0 сая төгрөгийн шилжүүлгээр санхүүжилтийн эх үүсвэрийг бууруулаагүй, зарлагын дүнд тохируулах бичилт хийгээгүй тайлагнасан,	1	34.0			1	34.0	1	34.0				
Мөнгөн гүйлгээний тайланд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 2.3 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг хөрөнгө оруулалтын зардлаар бүртгэж тайлагнаагүй,	1	2.3			1	2.3	1	2.3				
Аймгийн ИТХ-аас сумдын өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх, Улаан загалмайн дунд шатны хорооны үйл ажиллагааг дэмжих, сургалт арга хэмжээнд зориулан олгосон 3.9 сая төгрөгийн дэмжлэг санхүүжилтийг 131103 тоот дансанд тайлагнасан,	1	3.9			1	3.9	1	3.9				
Санхүүгийн үр дүнгийн тайланд нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 1.5 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн	1	1.5			1	1.5	1	1.5				
Санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн 3 дугаар улирлын элэгдэл хорогдлын зардлыг 1.8 сая төгрөгөөр дутуу тайлагнасан	1	1.8	1	1.8			1	1.8				
Төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 0.4 сая төгрөгийн караоке спикерийг аж ахуйн материалын зардалд тайлагнаж, хөрөнгийн орлогод бүртгээгүй байна	1	0.4			1	0.4	1	0.4				
Дүн	6	43.9	1	1.8	5	42.1	6	43.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит 14 дүгээр хуралдаан, хүндэтгэлийн баярт зориулж 0.8 сая төгрөгийн 33 ширхэг бэлэг, 0.1 сая төгрөгийн 4 ширхэг архи, 0.2 сая төгрөгийн 18 ширхэг шампанскийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан байна	1	1.1	1	1.1								
Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/35 дугаар захирамжаар "Сумын хурдан тэмээний уралдаан зохион байгуулах" үйл ажиллагаанд зориулж 11.9 сая төгрөгийн хөрөнгө зарцуулж, "Гайхамшигт Мандал" ХХК-д гэрээ байгуулан шилжүүлсэн байна.	1	11.9			1	11.9						
Бараа материалын тайланд бодитоор хүлээж аваагүй 20ш ананас, 325ш мэндчилгээ, 52ш медаль, 30ш өргөмжлөлийг орлогоор бүртгэж, зардлаар тайлагнасан, бараа материалын үлдэгдлээс бөөн дүнгээр зарлага гаргаж бүртгэл хөтөлсөн байна.	1	0			1	0						
Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга нь ИТХ-ын даргын 2023 оны А/38 дугаар захирамжаар албан хаагчдад ажлын үр дүнгийн урамшуулал цалин олгохдоо өөрийн нэрийг оруулан 1.5 сая төгрөгийн урамшуулал авч давуу байдал үүсгэсэн байна.	1	1.5					1	1.5				
Хурлын даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/34 дугаар захирамжаар албан хаагчид нүүрсний үнийн дэмжлэг үзүүлэхдээ ХХОАТ суутган тооцоогүй байна.	1	0.1					1	0.1				
Дүн	4	14.6	1	1.1	1	11.9	2	1.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны сайтад 12 мэдээлэл хоцроосон, тухайн жилийн төсөв, дараа жилийн төсвийн төсөл, аудитын дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, 5 сая төгрөгөөс дээш орлогын 135,304,000 төгрөгийн 11 ажил гүйлгээ, хөрөнгө зарцуулсан шийдвэрийн 13,008,000 төгрөгийн 10 гүйлгээ, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэлийг тус тус мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.3, 6.1.5, 6.4.5, 6.10, 7 дугаар зүйлийн 7.1-д заасантай тус тус нийцэхгүй байна.	1	1			1	1		
Дүн	1	1			1	1		